



## БИЧИЛ ЗЭЭЛДЭГЧИЙН АМЬ НАСНЫ ДААТГАЛЫН БАТАЛГАА

Энэхүү даатгалын баталгааг Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 283 тоот тогтоолоор Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан “Коннектайф Даатгал” ХХК нь Иргэний хууль, Даатгалын тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм журмыг удирдлага болгон даатгуулагчид гаргаж байна.

### Даатгуулагчийн мэдээлэл

Овог	Оршин суугаа хаяг
Нэр	Утасны дугаар
Регистрийн дугаар/ИБД	И-мэйл хаяг

### Бенефишерийн мэдээлэл

Овог	Нас
Нэр	Хүйс
Регистрийн дугаар	Холбоо барих утас

### Даатгалын гэрээний хураангуй

Даатгалын зүйл	Даатгуулагчийн амь нас
Даатгалын эрсдэл	Даатгуулагч гэрээний нөхөн төлбөр олгохгүй нөхцөлд зааснаас бусад нөхцөлийн улмаас амь нас эрсдэх;
Даатгалын үнэлгээ	Даатгалын тохиолдол гарсан өдрийн байдлаарх ..... хүртэлх төгрөгийн зээлийн төлбөр байх бөгөөд зээлийн төлбөрт зээлдэгчид үүссэн авлага, шимтгэл, нэмэгдүүлсэн хүү, хүү, үндсэн зээлийн дүн багтсан байна.
Даатгалын нөхөн төлбөр	Даатгалын үнэлгээнд зааврын дагуу нөхөн төлбөрийг нэг удаа төлнө

### Даатгалын гэрээний хугацаа

Эхлэх огноо	Дуусах огноо
-------------	--------------

### Банк бус санхүүгийн байгууллагын мэдээлэл

Банк бус санхүүгийн байгууллагын мэдээлэл

### Гэрээний ерөнхий нөхцөл

- Даатгуулагч амь насаа алдсан тохиолдолд даатгагч нөхөн төлбөрийг олгоно.
- Даатгуулагчийн даатгуулах боломжит нас нь 18-54 нас байх бөгөөд Даатгалын хамгаалалт нь даатгуулагч 55 нас хүрсэн өдрөөр дуусгавар болно.
- Нөхөн төлбөрийг зөвхөн банк бус санхүүгийн байгууллагын зээлийн төлбөрийг төлөхөд ашиглана. Нөхөн төлбөрийг даатгуулагчийн хувийн эхсүл өөр этгээдийн данс руу шилжүүлэхгүй бөгөөд зөвхөн ....-ийн дансанд шилжүүлнэ.
- Гэрээний хугацаанд даатгалын тохиолдол гараагүй.

Энэхүү Даатгалын баталгаа нь №..... Даатгалын гэрээний салшгүй хэсэг байна

**БИЧИЛ ЗЭЭЛДЭГЧИЙН АМЬ НАСНЫ ДААТГАЛЫН ГЭРЭЭ**

Энэхүү даатгалын гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г,

Нэг талаас регистрийн 8427976 дугаартай "Коннектайф Даатгал" ХХК (цаашид "Даатгагч" гэх),

Нөгөө талаас ИБД/регистрийн дугаартай ..... овогтой ..... (цаашид "Даатгуулагч" гэх, тус тусад нь "Тал", хамтад нь "Талууд" гэх) нар нь доорх нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1 Энэхүү даатгалын Гэрээгээр Даатгуулагч нь даатгалын зүйлээ Даатгагчид даатгуулж даатгалын хураамж төлөх, Даатгагч нь даатгалын тохиолдол гарсан үед Гэрээнд заасан нөхцөлийн дагуу нөхөн төлбөр олгохтой холбоотой харилцааг зохицуулна.

1.2 Талууд Гэрээг хэрэгжүүлэхдээ Иргэний хууль, Даатгалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

**ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР**

2.1 Энэхүү Гэрээнд дурдагдсан нэр томьёог доорх утгаар ойлгоно.

2.1.1. "Даатгагч" гэж урт хугацааны даатгалын тусгай зөвшөөрөлтэй "Коннектайф Даатгал ХХК"-ийг;

2.1.2. "Даатгуулагч" гэж даатгалын эрсдэлийг даатгуулж хураамж төлөх, даатгалын тохиолдол үүсэхэд Даатгагчаас олгох нөхөн төлбөрөөр зээлээ төлүүлэхийг зөвшөөрсөн иргэнийг;

2.1.3. "Даатгалын зүйл" гэдэгт Даатгуулагчийн амь нас;

2.1.4. "Даатгалын эрсдэл" гэдэгт даатгалын зүйлд гэрээнд заагдсан шалтгаанаар хохирол учруулж болох нөхцөл, орчныг;

2.1.5. "Даатгалын тохиолдол" гэж даатгалын зүйлд даатгалын эрсдэлийн улмаас учирсан хохирол, тохиролцсон болзол бүрдэхийг;

2.1.6. "Даатгалын үнэлгээ" гэж даатгалын тохиолдол гарсан өдрийн байдлаарх ..... хүртэлх төгрөгийн зээлийн үлдэгдлийг;

2.1.7. "Даатгалын хураамж" гэж Даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө Даатгагчид тохиролцсон дүн, давтамжийн дагуу төлөх мөнгөн төлбөрийг;

2.1.8. "Даатгалын нөхөн төлбөр" гэж даатгалын гэрээнд заасан даатгалын тохиолдол үүссэн үед банк бус санхүүгийн байгууллагад төлөх мөнгөн дүнг;

2.1.9. "Зээлийн гэрээ" гэж ..... болон даатгуулагч нарын хооронд харилцан тохиролцож байгуулсан зээлийн гэрээг;

2.1.10. "Даатгалын гэрээний хугацаа" гэж Гэрээ хүчин төгөлдөр үйлчилж эхлэх өдрөөс дуусах өдрийг дуустал хугацааг;

2.1.11. "Даатгалын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах" гэж Гэрээний хугацаанд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр Гэрээний нөхцөл болон Гэрээний хавсралтуудыг нэмэх, хасах, агуулгыг нь өөрчлөхийг;

2.1.12. "Нөхөн төлбөр хүлээн авагч" гэж .....-ийг;

2.1.13. "ICD10 код" гэж ДЭМБ-аас баталсан, дэлхий даяар өвчлөлийн (morbidity) ба нас баралтын (mortality) шалтгааныг стандартчлан кодлох олон улсын ангиллыг;

2.1.14. "Даатгуулагчийн хувийн мэдээлэл" гэж Гэрээтэй холбоотойгоор Даатгуулагчаас цуглуулсан бүх төрлийн мэдээллийг. Үнд: овог, нэр, регистрийн дугаар, оршин суугаа хаяг, иргэншил гэх зэрэг Даатгуулагчийг тодорхойлох боломжтой мэдээллийг;

2.1.15. "Хураамжийн хүлээлгийн хугацаа" гэж даатгуулагч даатгалын хураамжийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд, даатгалын гэрээг цуцлахгүйгээр хэвээр үргэлжлэх, даатгалын хураамжийг нөхөн төлөх боломж бүхий хугацааг;

2.1.16. "Хүлээлгийн хугацаа" гэж Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн даатгалын хамгаалалт эхлэх хүртэлх хугацааг;

2.1.17. "Бенефишер" гэж даатгалын тохиолдол үүссэнээр даатгагчид нөхөн төлбөрийн баримт бичиг бүрдүүлэн өгөх даатгалын баталгаанд заасан иргэнийг;

2.2 Энэхүү Гэрээнд хэрэглэгдсэн, Гэрээнд тодорхой тайлбарлаагүй мэргэжлийн нэр томьёо, ойлголтыг Монгол Улсын хууль, тогтоомж, даатгалын салбарын эрх зүйн акт болон олон улсын хүлээн зөвшөөрсөн стандарт, жишиг ойлголтын дагуу тайлбарлан хэрэглэнэ.

**ГУРАВ. ДААТГАЛЫН ЗҮЙЛ, ТОХИОЛДОЛ, ҮНЭЛГЭЭ, ХУРААМЖ**

- 3.1 Даатгалын зүйл нь даатгуулагчийн амь нас байна.
- 3.2 Даатгалын эрсдэл нь Даатгуулагч энэ гэрээний нөхөн төлбөр олгохгүй нөхцөлд зааснаас бусад шалтгааны улмаас нас барах байна.
- 3.3 Хүлээлгийн хугацаа нь Гэрээ хүчин төгөлдөр болсноос эхлэн 90 (ер) хоногийн хугацаатай байна.
- 3.4 Даатгуулагч нь Даатгагчтай энэхүү гэрээний хугацаа дууссанаас хойш 2 сарын дотор дахин гэрээ байгуулсан тохиолдолд нь хүлээлгийн хугацаагүй байх бол 2 сар болон түүнээс дээш хугацааны дараа дахин гэрээ байгуулах тохиолдолд хүлээлгийн хугацаа нь 60 (жар) хоног байна.
- 3.5 Даатгалын хамгаалалт нь хүлээлгийн хугацаа дууссанаар эхэлж, даатгалын баталгаанд заасан гэрээний хугацаа дуусах хүртэл Даатгуулагчид үйлчилнэ.
- 3.6 Хураамжийн хүлээлгийн хугацаа нь төлбөрийн нэхэмжлэх гарсан өдрөөс хойш 60 (жар) хоног байна.
- 3.7 Хураамжийн хүлээлгийн хугацаанд даатгалын тохиолдол бий болсон бол Гэрээг хүчин төгөлдөрт тооцож, нөхөн төлбөр олгоно. Нөхөн төлбөрийг олгохдоо төлөгдөөгүй сарын даатгалын хураамжийг нөхөн төлбөрөөс хасаж тооцно.
- 3.8 Хураамжийн хүлээлгийн хугацаа хэтэрсэн тохиолдолд Гэрээ дуусгавар болох бөгөөд Талуудын эрх, үүрэг дуусгавар болно.
- 3.9 Энэхүү гэрээний дагуу Даатгуулагчийн Даатгагчид төлж буй хураамж нь даатгалын суурь хураамж бөгөөд ...-ээс авсан эзлээс аливаа байдлаар хасагдах дүн биш болно.

**ДӨРӨВ. ДААТГАЛЫН ТОХИОЛДОЛ**

- 4.1 Даатгуулагч даатгалын гэрээний хугацаанд нөхөн төлбөр олгохгүй нөхцөлөөс бусад шалтгаанаар нас барсан нь тогтоогдсон бол бичил эзэлдэгчийн амь насны даатгалын тохиолдол бий болсонд тооцно.

**ТАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, ДУУСГАВАР БОЛОХ НӨХЦӨЛ**

- 5.1. Даатгалын гэрээ нь даатгалын баталгаанд заасан хугацаагаар байгуулагдана.
- 5.2. Даатгалын гэрээ дараах тохиолдолд дуусгавар болно.
  - 5.2.1. Хууль, гэрээгээр тогтоосон хугацаа дуусгавар болсон;
  - 5.2.2. Даатгагч дампуурсан, татан буугдсан;
  - 5.2.3. Шүүх гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцсон;
  - 5.2.4. Даатгуулагч 55 насанд хүрсэн;
  - 5.2.5. Даатгуулагч нь нөхөн төлбөр авах зорилгоор худал мэдээлэл өгсөн, эсхүл нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлсэн нь баримтаар нотлогдсон бол Даатгагчийн нэг талын санаачилгаар;
  - 5.2.6. Даатгуулагч нь Гэрээг хугацаанаас нь өмнө цуцалснаар;
  - 5.2.7. Даатгуулагч зээлийн үлдэгдлээ төлж дууссан;
  - 5.2.8. Даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн;
- 5.3. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцож, нэмэлт гэрээ байгуулсны үндсэн дээр шийдвэрлэнэ.
- 5.4. Гэрээг цуцалснаас үүсэх хураамжийн буцаалт
  - 5.4.1. Даатгуулагч, түүний өв залгамжлагч нь хуурамч бичиг баримт бүрдүүлэх замаар нөхөн төлбөр авахыг оролдсон бол Даатгагчийн санаачилгаар гэрээг цуцалж, хураамжийг буцаан олгохгүй.
  - 5.4.2. Даатгуулагч энэ гэрээний хугацаа дуусахаас өмнө эсвэл даатгалын тохиолдол бий болохоос өмнө гэрээг цуцалсан тохиолдолд төлсөн хураамжийг буцаан олгохгүй.

**ЗУРГАА. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ**

- 6.1 Даатгагч нь дараах эрх, үүрэгтэй байна.
  - 6.1.1 Даатгалын тохиолдол бий болсон үед Даатгагч даатгалын тохиолдлын улмаас учирсан хохирлын шалтгаан нөхцөл, хэмжээг үнэн зөв тогтоолгох зорилгоор мэргэжлийн холбогдох байгууллагад хандаж дүгнэлт гаргуулах болон нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход шаардлагатай аливаа мэдээг Даатгуулагчаас шаардах;
  - 6.1.2 Даатгалын нөхөн төлбөрийг олгохоос татгалзах нөхцөл бүрдсэн тохиолдолд төлбөрийг бүрэн эсвэл хэсэгчлэн олгохоос татгалзах;
  - 6.1.3 Даатгуулагчийн гаргаж өгсөн мэдээ, баримт бичгийн үнэн, зөв эсэхийг шалгах, шаардлагатай бол мэдээллийн талаар эрх бүхий байгууллага, хуулийн этгээдээс тодруулга авах;

- 6.1.6 Даатгалын баталгааг гэрээнд заасан хугацаанд даатгуулагчид олгох;
  - 6.1.7 Нөхөн төлбөр олгохоос татгалзсан тохиолдолд үндэслэлээ тодорхой гаргаж, даатгуулагчид бичгээр эсхүл цахимаар мэдэгдэх;
  - 6.1.8 Даатгалын тохиолдол бий болж, Даатгагчийн төлбөл зохих нөхөн төлбөрийн хэмжээг тогтоосны дараа үүргээ гүйцэтгэх;
  - 6.1.9 Гэрээний нөхцөлийг Даатгуулагчид танилцуулах;
  - 6.1.10 Монгол Улсын хуульд зааснаас бусад тохиолдолд Даатгуулагчийн талаарх мэдээ, баримт бичгийн нууцыг задруулахгүй, бусдад дамжуулахгүй байх;
- 6.2 Даатгуулагч нь дараах эрх, үүрэгтэй байна.
- 6.2.1 Даатгалын тохиолдол болсон үед хууль болон Гэрээний нөхцөлийн дагуу нөхөн төлбөрөөр зээлийн төлбөрийг суутгахыг зөвшөөрч байна;
  - 6.2.2 Даатгалын нөхцөл, үнэлгээ, хураамжийн хувь хэмжээний талаарх мэдээлэл, нэмэлт тодруулга шаардах;
  - 6.2.3 Нөхөн төлбөртэй холбоотой баримт бичгийг Даатгагчид үнэн зөв гаргаж өгөх;
  - 6.2.4 Даатгалын хураамжийг Гэрээнд заасан хугацаа, хэмжээгээр Даатгагчид төлөх;
  - 6.2.5 Даатгалын гэрээг нэг талын санаачилгаар цуцлах;
  - 6.2.6 Даатгуулагч нэг ашиг сонирхлыг хэд хэдэн даатгагчид нэгэн зэрэг даатгуулсан бол энэ тухай Даатгагч бүрт нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.
  - 6.2.7 Даатгуулагч нь Гэрээ байгуулахдаа өөрийн мэдэж байгаа аюул учруулах буюу даатгалын тохиолдол бий болоход нөлөөлж болох ноцтой нөхцөл байдал, түүнчлэн Гэрээ байгуулснаас хойш бий болсон нөхцөл байдал болон даатгалын тохиолдол бий болох нөхцөл орчин бүрдсэн тухай Даатгагчид нэн даруй мэдээлэх үүрэгтэй.

## ДОЛОО. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

- 7.1 Бенефишер нь ....-аар дамжуулан Даатгалын тохиолдол бий болсон үед энэхүү гэрээнд тусгагдсан баримт бичгийг даатгагчид үнэн зөв, бүрэн гүйцэд, хууль зүйн дагуу бүрдүүлэн, даатгалын тохиолдол бий болсон өдрөөс хойш хуанлийн 120 хоногийн дотор хүлээлгэн өгнө.
- 7.2 Даатгагч Гэрээнд заасан нөхөн төлбөрийн баримтуудыг бүрэн гүйцэд хүлээн авснаас хойш ажлын 14 хоногт багтаан шийдвэрлэнэ. Бенефишер нь нөхөн төлбөрийн баримт бичгийг бүрэн ирүүлээгүй тохиолдолд даатгагч нь 30 хүртэл хоногийн хугацаа олгож болно.
- 7.3 Нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэсэн тохиолдолд зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн хамт банк бус санхүүгийн байгууллагад нэг удаа даатгалын үнэлгээний дагуу ажлын 5 хоногт шилжүүлнэ.
- 7.4 Хэрвээ даатгалын тохиолдол болсон эсэх нь эргэлзээтэй эсвэл холбогдох баримт бичгийн нотолгоог хангалтгүй гэж үзсэн, нэмэлт мэдээлэл цуглуулах, мэргэжлийн байгууллагаар шалгуулах шаардлага гарсан, даатгалын тохиолдол нь төрийн захиргааны байгууллагад хянагдаж байгаа эсвэл эрүүгийн болон иргэний хэрэг үүсгэгдсэн бол шүүхийн шийдвэр гарах хүртэл Даатгагч даатгалын нөхөн төлбөр шийдвэрлэлтийг хойшлуулах эрхтэй.
- 7.5 Даатгуулагч нь Гэрээнд заасан нөхөн төлбөрийн баримт бичгийг дутуу бүрдүүлсэн бол нөхөн төлбөр шийдвэрлэгдэхгүй бөгөөд Даатгагч нь шаардлагатай нэмэлт баримт бичгийг хугацаа тогтоон даатгуулагчаас гаргуулж болно.
- 7.6 Гэрээнд заасан нөхөн төлбөр олгохгүй нөхцөл тогтоогдсон тохиолдолд Даатгагч нь нөхөн төлбөр олгохоос татгалзаж, татгалзсан үндэслэлийг бичгээр эсвэл цахимаар Даатгуулагчид мэдэгдэнэ.
- 7.7 Даатгуулагч Гэрээний нөхөн төлбөр олгохгүй нөхцөл хэсэгт зааснаас бусад тохиолдлын улмаас нас барсан бол даатгалын тохиолдол гарсан өдрийн байдлаарх ..... хүртэлх төгрөгийн зээлийн үлдэгдлийг нөхөн төлбөрт тооцон олгоно.
- 7.8 Даатгагчийн олгох нийт нөхөн төлбөрийн хэмжээ даатгалын үнэлгээнээс хэтрэхгүй байна.
- 7.9 Бенефишер нь дараах баримт бичгийг заавал бүрдүүлж Даатгагчид ирүүлнэ. Үүнд:
- 7.9.1 Даатгалын тохиолдолд үүссэн болохыг нотолсон эмнэлгийн магадлагаа, нас барсны гэрчилгээ;
  - 7.9.2 Шүүх эмнэлгийн шүүх эмнэлгийн дүгнэлт, тодорхойлолт;
  - 7.9.3 Зээлийн гэрээний хуулбар;
  - 7.9.4 Зээлийн гэрээний үлдэгдлийн тодорхойлолт;
  - 7.9.5 Шаардлагатай гэж үзвэл бусад баримт, тодорхойлолт
- 7.10 Буруутай этгээдээс нэхэмжлэх
- 7.10.1. Даатгагч нөхөн төлбөрийг олгосон нөхцөлд буруутай этгээдээс төлбөр нэхэмжлэх Даатгуулагчийн эрх нь даатгалаар олгогдсон нөхөн төлбөр, түүнтэй холбогдон гарсан зардлын хэмжээгээр Даатгагчид шилжинэ.
  - 7.10.2. Даатгалын нөхөн төлбөрийг зохих журмын дагуу олгосноос хойш Даатгуулагч гарсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн тохиолдолд Даатгуулагч нь олгогдсон нөхөн төлбөрийг үл маргах журмаар даатгагчид шилжүүлнэ

7.10.3. Хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр даатгуулагчийг нас барсанд тооцож нөхөн төлбөр олгосны дараа шүүхийн шийдвэр Иргэний хуулийн 24.6-д заасны дагуу хүчингүй болсон тохиолдолд олгосон нөхөн төлбөрийг Даатгуулагчаас буцаан нэхэмжилнэ.

7.10.4. Хуурамч бичиг баримт бүрдүүлж нөхөн төлбөр авсан нь тогтоогдсон.

7.10.5. Буруутай этгээдээс хохирлыг нэхэмжлэн авах Даатгагчийн эрхийг даатгуулагчийн зүгээс ямар нэгэн хэлбэрээр хязгаарласан эсвэл багасгасан тохиолдолд Даатгагч Даатгуулагчид олгосон нөхөн төлбөрийг тухайн хэмжээгээр буцаан нэхэмжилнэ.

7.11 Байгалийн гамшиг, гал, усны аюулаас хүний амь, эрүүл мэнд хохирсон, үед талууд зохих мэргэжлийн байгууллагуудтай хамтран хохирлын шалтгаан, хэмжээг тогтоох комисс томилон ажиллах ба комиссын бүрэлдэхүүнд даатгагч, даатгуулагчийн төлөөлөгч байхаас гадна шаардлагатай бол хууль хяналт, гал, ус цаг уурын албаны төлөөлөгч зэрэг холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулж болно. Томилогдсон комисс даатгалын тохиолдлын шалтгаан, хохирлын хэмжээг газар дээр нь шалган шинжлэн судалж, хохирлын шалтгааныг тогтоосон актыг үйлдэнэ.

## НАЙМ. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХГҮЙ НӨХЦӨЛ

8.1. Дараах үйлдэл, шалтгааныг даатгалын тохиолдолд тооцохгүй бөгөөд нөхөн төлбөр олгохгүй. Үүнд:

8.1.1. Нөхөн төлбөр авах зорилгоор худал мэдээлэл өгсөн, хуурамч баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;

8.1.2. Даатгуулагчийн гэр бүлийн гишүүн, хууль ёсны эсвэл гэрээслэлийн дагуу өв залгамжлагч нь даатгалын эрсдэлийг бий болгосон, захиалсан, оролцсон;

8.1.3. Даатгуулагч хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдсан;

8.1.4. Даатгуулагч гэмт хэрэг үйлдэхийг завдах, эсвэл үйлдэж байх үед даатгалын эрсдэл үүссэн;

8.1.5. Эрсдэлтэй спортоор хичээллэх, оролцож байх үед даатгалын эрсдэл үүссэн. (Ууланд авирах, хаданд авирах, автомашин, мотоциклийн уралдаан, шүхэр болон, параглайдинг, үсрэлттэй шумбалт, гүн шумбалт, Хувийн агаарын хөлөг (тийрэлтэт онгоц, нэг роторт нисдэг тэрэг, бусад ижил төрлийн хэрэгсэл) жолоодох, Бокс, тулааны урлагийн тэмцээн (мэргэжлийн түвшинд);

8.1.6. Сураггүй алга болсны улмаас нас барсны гэрчилгээ авсан;

8.1.7. Даатгуулагчид хураамжийн хүлээлгийн хугацаа дуусахад хураамжаа төлөөгүй байх үед даатгалын тохиолдол бий болсон;

8.1.8. Даатгуулагч амиа хорлох болон өөртөө хор учруулсан (ICD10 код: X60 – X84, Y87.0);

8.1.9. Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийг эмчийн заалтгүйгээр хэрэглэх, түүнчлэн тухайн бодисын хэрэглээнээс үүдэлтэй хордлого, сэтгэцийн эмгэгээр нас барсан (ICD-10 код: X40–X49, Y10–Y14, F11–F19);

8.1.10. ХДХВ/ДОХ-ийн өвчлөлөөр нас барсан (ICD10 код: B20 – B24);

8.1.11. Цөмийн, химийн, биологийн зэвсэг, цацрагийн нөлөөнд өртсөн (ICD10 код: Y36.5 – Y36.7, W88, W90);

8.1.12. Дайны ажиллагаа, Энх-тайвны ажиллагаа, Алан хядлагын үйлдэл, Нийтийг хамарсан үйлмээн самуунд өртсөн (ICD10 код: Y35.0–Y35.9 дэд код, Y36, Y38 бүх дэд код);

8.1.13. Цар тахлын онцгой нөхцөл (ICD10 код: A40–A41, U07.1);

8.1.14. Даатгалын гэрээнд заасан хүлээлгийн хугацаанд Даатгуулагч нас барсан;

8.1.15. Бенефишер нь энэ гэрээнд заасан хугацаанд нөхөн төлбөрийн баримт бичгээ бүрдүүлэн өгөөгүй;

## ЕС. МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ

9.1 Энэхүү Гэрээг байгуулахад болон нөхөн төлбөр олгоход шаардлагатай мэдээллүүдийг бенефишер нь бүрэн, үнэн зөв Даатгагчид гаргаж өгөх үүрэгтэй бөгөөд Даатгуулагчийн хувийн мэдээллийг Даатгагч нь хууль тогтоомжид заасны дагуу цуглуулж, ашиглаж, боловсруулна.

9.2 Даатгагч нь Гэрээний хүрээнд олж мэдсэн Даатгуулагчийн хувийн мэдээллийг зөвхөн Гэрээнд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ашиглаж, боловсруулах үүрэгтэй. Даатгуулагчийн хувийн мэдээллийг зөвхөн холбогдох хуульд заасан үндэслэлийн дагуу, эсхүл Даатгуулагч зөвшөөрөл өгсөн тохиолдолд, эсхүл Гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор гуравдагч этгээдэд дамжуулж болно. Үүнд: даатгалын хураамж цуглуулах, даатгалын үйлчилгээг үзүүлэх, сайжруулах, шинээр бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгох (маркетингийн зорилгоор), зээлийн гэрээ болон даатгалтай холбоотойгоор холбогдох банк бус санхүүгийн байгууллагатай мэдээлэл солилцох зэрэг хамаарна. Харин Даатгуулагчийн эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг хууль тогтоомжид зааснаас бусад үндэслэлээр, эсхүл даатгалын нөхөн төлбөрийг шийдвэрлэх, баталгаажуулахад зайлшгүй шаардлагатай тохиолдол гарснаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд дамжуулахгүй.

9.3 Даатгалын нөхөн төлбөрийн баримт бичгийг бүрэн хүлээн авснаас хойш гэрээнд заасан хугацаанд нөхөн төлбөр олгоогүй тохиолдолд Иргэний хуулийн 232.6 дахь хэсэгт заасны дагуу хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар алданги тооцож Даатгуулагчид олгоно.

## АРАВ. БУСАД ЗҮЙЛ

10.1 Гэрээтэй холбоотой гарсан маргааныг талууд харилцан тохиролцож, эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Хэрэв ийнхүү шийдвэрлэж чадаагүй тохиолдолд холбогдох маргааныг Санхүүгийн Зохицуулах Хороонд хандаж шийдвэрлүүлэх бөгөөд талууд Санхүүгийн Зохицуулах Хорооны шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Монгол улсын шүүхээр маргааныг шийдвэрлүүлнэ.

10.2 Энэхүү гэрээг 2 хувь үйлдсэн бөгөөд гэрээний эх хувиуд хууль зүйн адил хүчинтэй байна.

10.3 Даатгалын гэрээний нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

10.4 Даатгуулагч нь энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар бүх нөхцөлийг хүлээн зөвшөөрч, танилцсан гэж үзнэ.

ДААТГАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"Коннектлайф Даатгал" ХХК-ийг төлөөлж

Гүйцэтгэх захирал

\_\_\_\_\_

ДААТГУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Иргэн

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

гарын үсэг



Хайртай хүмүүсийн тань санхүүгийн тогтвортой байдалд зориулав